

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРААР ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ЗАА-2021/85/ШТА-ГА

Улиастай сум 2021 он



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Г.Хашцэцэг
Утас: 7046-3783, Цахим хаяг: khashtsetsegg@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Заяа
Утас: 92038288, Цахим хаяг: zayag@audit.gov.mn
Аудитор Д.Пүүжмаа
Утас: 99080797, Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёог.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
 БҮЛЭГ 1. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРААР ДАМЖИН ХЭРЭГЖСЭН 2020 ОНЫ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.....	5-11
 БҮЛЭГ 2. ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАГНАЛ, ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	12-14
 ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	15
ДҮГНЭЛТ	16
ЗӨВЛӨМЖ:	17-18
 ХАВСРАЛТУУД.....	19-22

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХХААХҮ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УХЭШХ	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

Хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Малд үзлэг ангилалт хийх зардал олгосон жагсаалт	20
Хавсралт 2	Малын генетик нөөц, төлөв байдлыг үнэлэх ажлын зардал олгосон жагсаалт	21
Хавсралт 3	Үлийн цагаан оготно устгалын зардал олгосон жагсаалт	22
Хавсралт 4	Алдаа зөрчлийн нэгтгэл	23

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй
Аудитын зорилт	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/15 тоот тушаалаар баталсан Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ. “Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжин хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • <i>Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжин хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?</i> • <i>Хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн тайлагнал, хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй байна уу?</i>
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газар, сумдын ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдийн 2019, 2020 оны үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Төрийн аудит, Тулгуур зарчим MNS 6817-1:2020 стандарт, Гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудит аудит хийх журам, гүйцэтгэлийн аудитын журам MNS 6817-7:2020, зэргийг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, санхүүгийн болон ажлын тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Г.Хашцэцэг нар хянан удирдаж, ахлах аудитор Г.Заяа, аудитор Д. Пүүжмаа нар 2021 оны 04 дүгээр сарын 26-аас эхлэн 2021 оны 06 дугаар сарын 26-ний хооронд гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРААР ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БУЙ 2020 ОНЫ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

1.1 2020 онд үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг олон нийтийг хамруулан, төлөвлөснөөс их талбай хамруулан үр дүнтэй зохион байгуулжээ.

1.1.1 Сумдын Засаг дарга нарын 2019 оны үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын үр дүн шаардлагын түвшинд хүрээгүй, 2020 оны тэмцэх ажил үр дүнтэй хэрэгжжээ.

ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн А/89 тоот тушаалаар аймагт 35.0 мянган га талбайд үлийн цагаан оготнотой тэмцэхэд зориулан 56,000.0 мянган төгрөгийн, ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/89 тоот тушаалаар 60.0 мянган га талбайд үлийн цагаан оготнотой тэмцэхэд зориулан 96,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус хуваарилжээ.

Аймгийн ХХААГ нь 2019 онд Тосонцэнгэл, Тэс, Сонгино, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Цагаанхайрхан зэрэг сумдад 50,250.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, хяналтын зардалд 5,250.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн ХХААГ-аас үлийн цагаан оготнотой тэмцэх Цагаанхайрхан, Тэс сумыг сонгохдоо УХЭШХ-ийн Мэрэгч судлалын лабораторийн хийсэн үлийн цагаан оготны тархалтын судалгааны үр дүнд үндэслээгүй байна.

Дээрх 6 сумдын Засаг дарга нар захирамж гарган үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын хэсгийг томилон, 454 иргэнийг оролцуулан, сумдын 16 багийн нутаг дэвсгэрийн 35.0 мянган га талбайд үлийн цагаан оготныг устгасан байна.

Үлийн цагаан оготнотой тэмцсэн сумдын зардал дараах байдалтай байна.

	Сумдын нэр	Тэмцсэн талбай /га/	Оролцсон хүний тоо	Олгосон санхүүжилт	Зарцуулалт		
					Шатахуун	Ажлын хөлс	Материал бусад зардал
1	Тосонцэнгэл	3000	60	5800.0	900.0	3600.0	450.0
2	Цэцэн-Уул	6000	70	8700.0	5451.7	2100.0	1148.2
3	Сонгино	5000	184	5800.0	3792.0	900.0	1107.9
4	Тэс	7000	40	10150.0	1092.0	2552	1460.0

5	Эрдэнэхайрхан	7000	100	10150.0	2460.9	6000.0	1689.0
6	Цагаанхайрхан	7000		10150.0			
Дүн		35,000	454	50,750.0	13,696.6	15,152.0	5,855.1

Сумдаас ирүүлсэн тайлантай танилцахад Сонгино сумын Засаг дарга бусад 5 сумаас бага зардлаар их талбайг хамруулан үлийн цагаан оготнотой тэмцсэн сайн тал ажиглагдлаа.

Харин Цагаанхайрхан сумын Засаг даргын үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын зарцуулалтыг хууль хяналтын байгууллага шалгаж байгаа бол Тэс сумын Засаг даргын тэмцэх ажлын зарцуулалт нь ашиглангийн шинжтэй байх магадлалтай тул холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

Тэс, Тосонцэнгэл сумдын Засаг дарга нар үлийн цагаан оготнотой тэмцэх зардлаас 1,530.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, Тосонцэнгэл сумын Засаг даргын 1 га талбайд үлийн цагаан оготнотой тэмцэх зардал тогтоосон хэмжээнээс 1,000.0 мянган төгрөгөөр илүү байсан, Цэцэн-Уул сумын Засаг дарга тэмцэх зардлыг зарцуулахдаа Төрийн сангийн төлбөр тооцооны журам зөрчсөн байна.

Аймгийн ХХААГ-аас Тэс, Тосонцэнгэл, Цагаанхайрхан, Цэцэн-Уул сумдын үлийн цагаан оготнотой тэмцэх талбайн хэмжээ, үлийтэй тэмцэх ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналд тавих хяналт хангалтгүй байсан нь үр дүн буурахад нөлөөлсөн байна. 2019 онд үлийн цагаан оготнотой тэмцэх шаардлагатай гэж дүгнэсэн талбайн 10.2 хувийг хамруулахаас 6.2 хувийг хамруулснаас харахад үлийн цагаан оготно устгах ажлын үр дүн шаардлагын түвшинд хүрээгүй байна гэж үзлээ.

2020 онд аймгийн Засаг даргын “Бэлчээр хамгаалах бүх нийтийн арга хэмжээг зохион байгуулах тухай” А/158 тоот захирамж гарч, 6 ажлын хэсэг томилогдон үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын санхүүжилтийг 21 сумдад ирүүлсэн саналыг үндэслэн хуваарилсан байна. /хавсралт 3/

Цагаанхайрхан, Ургамал, Тэс сумдад тэмцэх зардлыг хуваарилахдаа УХЭШХ-ийн Мэрэгч судлалын лабораторийн хийсэн үлийн цагаан оготны тархалтын судалгааны үр дүнд үндэслээгүй, Их-Уул, Отгон, Баянхайрхан, Тосонцэнгэл сумдад оготны тархалттай нь уялдуулаагүй илүү санхүүжилт олгосон, сумдаас ирүүлсэн

саналаас Баянхайрхан суманд 1,214.4 мянган төгрөгийн, Тэс суманд 1,435.0 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү хуваарилсан зэрэг зөрчил илэрлээ.



байна.


Сумдын Засаг дарга нар захирамж гарган үлийн цагаан оготной тэмцэх ажлын хэсгийг томилон, 4872 малчдыг татан оролцуулж сумдын 84 багийн нутаг дэвсгэрийн 164.5 мянган га талбайд үлийн цагаан оготныг устгасан байна.

Үлийн цагаан оготной тэмцэхдээ байгаль орчинд халгүй, энгийн механик нүхийг утах, ус цутгах, шувууны суултуур хийх, ундааны саваар конус суулгах зэрэг аргыг ашигласан бөгөөд устгасан газруудаа баримтжуулсан

Сумдаас ирүүлсэн тайлантай танилцахад 17 сумдын 1 га талбайд үлийн цагаан оготной тэмцэх зардал ХХААХҮЯ-аас тооцсон хэмжээ буюу 1600 төгрөгөөс бага байсан бөгөөд эдгээр сумдын Засаг дарга нар бага зардлаар үлийн цагаан оготно тархсан их талбайд тэмцэл явуулсан сайн тал ажиглагдлаа.

Гэтэл 1 га талбайд үлийн цагаан оготной тэмцэхдээ Их-Уул суманд 4885 төгрөгийн, Отгон суманд 3256 төгрөгийн, Тосонцэнгэл суманд 1813 төгрөгийн, Баянхайрхан суманд 1885 төгрөгийн зардал гаргасан нь тогтоосон хэмжээнээс нийт дүнгээрээ 13,494.3 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь санхүүжилтийн хуваарилалтыг үндэслэлтэй хийгээгүй, тэмцэх ажлын төлөвлөлт, гүйцэтгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байсныг харуулж байна. Цаашид сумдад санхүүжилтийг хуваарилахдаа үлийн цагаан оготны тархалтад үндэслэснээр нэгж талбайн тэмцэх зардлыг бууруулж, үр дүнг нэмэгдүүлэх боломжтой юм.

2020 онд үлийн цагаан оготной тэмцэх шаардлагатай гэж дүгнэсэн талбайн 7 хувийг хамруулахаас 13.5 хувийг хамруулсан тул үлийн цагаан оготно устгах ажил үр дүнд хүрсэн байна гэж үзлээ.



Үлийн цагаан оготно тэмцэх ажлын үр дүнг харьцуулж үзэхэд 2020 онд тэмцэх ажилд олон нийтийг хамруулснаар илүү үр дүнд хүрсэн нь харагдаж байна.

1.1.2. 2020 онд орон нутгийн төсвөөс хуваарилагдсан үлийн цагаан оготнотой тэмцэх зардлын 67.7 хувийг сумдын Засаг дарга нар үр дүнтэй зарцуулсан байна.

2019 онд үлийн цагаан оготнотой тэмцэх ажилд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй, бүх нийтийг татан оролцуулаагүй байна.

2020 оны үлийн цагаан оготнотой тэмцэх ажилд аймгийн Засаг даргын нөөц сангаас 20,000.0 мянган төгрөгийн, аймгийн Засаг даргын А/158 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар хуваарилагдсан төсөвт байгууллагуудаас 16,762.1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг, аймгийн ХЭДС-аас 24,780.0 мянган төгрөгийн, нийт 61,542.1 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсныг шалгахад дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын нөөц сангаас үлийн цагаан оготнотой тэмцэхэд зориулан 14,846.5 мянган төгрөгөөр шланк бэлтгэж, 2,153.5 мянган төгрөгийг хүнсний зардалд зарцуулсан байна. Бэлтгэсэн шланк, хүнсний зардлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон 6 ажлын хэсэгт хуваарилсан боловч ажлын хэсгүүд зарцуулалтын тайлангаа ирүүлээгүй байна.

Төсөвт байгууллагуудаас төвлөрүүлсэн хөрөнгөөс Цагаанхайрхан сумын Засаг дарга 1,122.5 мянган төгрөгийг, Алдархаан сумын Засаг дарга 877.9 мянган төгрөгийг, Ургамал сумын Засаг дарга 600.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан нь баримтаар нотлогдохгүй байна.

Түүнчлэн Баянхайрхан суманд үлийн цагаан оготной тэмцэхэд аймгийн Засаг даргын нөөц сангаас 2,700.0 мянган төгрөгийг нэмж олгосноор тус сум нь нийт 9,518.5 мянган төгрөгийг 5050 га талбайд тархсан үлийн цагаан оготной тэмцэхэд зарцуулжээ.

Баянхайрхан суманд төлөвлөснөөс 1.8 дахин их санхүүжилт олгосон байтал тус сумын 1 га талбайд үлийн цагаан оготно устгах зардал нь сумдын дундаж зардлаас 665 төгрөгөөр илүү байна.

Эндээс харахад зарим сумдад үлийн цагаан оготной тэмцэх санхүүжилтийг нэмэгдүүлэхийн хирээр нэгж талбайн тэмцэх зардал өссөн байгаа нь сумдад тэмцэх ажлын зохион байгуулалт, сумдын байгаль орчны байцаагч нараас тавих хяналт хангалтгүй байсныг харуулж байна.

1.2. Малын генетик нөөц, төлөв байдлыг үнэлэх ажил үр дүнтэй зохион байгуулж ажилласан байна.

1.2.1 Малын генетик нөөц, төлөв байдлыг үнэлэх ажилд төлөвлөгөөнөөс илүү мал хамруулжээ.

ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/169 дугаар тушаалаар аймагт 35,550 малыг генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлон үнэлэх ажилд нийт 19,197.0 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ.

Аймгийн ХХААГ уг ажлыг Яруу сумын “Жаргалант мал”, “Уран тэгш”, Алдархаан сумын “Окусан” зэрэг мал үржүүлэг, технологийн нэгжүүдээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

“Жаргалант мал” мал үржүүлэг, технологийн нэгж Идэр, Тэлмэн, Түдэвтэй, Ургамал сумдын 15845 толгой малд, “Окусан” мал үржүүлэг, технологийн нэгж Шилүүстэй, Тосонцэнгэл сумын 9955 толгой малд, “Уран тэгш” мал үржүүлэг Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан сумын 10540 толгой мал сүрэгт генетик нөөцийг тодорхойлох, үнэлэх ажлыг хийсэн байна.

Дээрх мал үржүүлэг, технологийн нэгжүүд гэрээнд заасны дагуу зөвлөмж зааврыг баримтлан сумдад генетик нөөцийг тодорхойлох, үнэлэх ажлыг зохион байгуулж, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан боловч малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд ангилсан малаа бүртгээгүй байна. Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программд бүртгэх ажлыг аймгийн ХХААГ-ын мэргэжилтнүүд бүрэн оруулж ажиллажээ.

Малын генетик нөөц төлөв байдлыг үнэлэхдээ төлөвлөгөөнөөс илүү малыг хамруулж ангилсан байна.

1.3.1 Малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх ажлын гүйцэтгэгчид гэрээний үүргээ бүрэн хэрэгжүүлсэн байна.

2019 онд ХХААХҮЯ-аас аймгийн хэмжээгээр Сартуул үүлдрийн 9700 хонь, Завхан буурал үүлдрийн 8750 ямаа, Тэс омгийн 509 адууг үзлэг ангилалтад хамруулж, анги чанарыг тогтоолгохоор нийт 15,444.2 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилжээ.

Аймгийн ХХААГазар малын үзлэг ангилалтыг хийж, цөм сүрэг бүрдүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгохдоо худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр Яруу сумын "Жаргалант мал сүрэг" мал үржүүлэг, технологийн нэгжтэй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.4-д заасан "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл олгоно", мөн хуулийн 33.1-д "Бараа ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын арга хэрэглэж болно" гэж тус тус заасныг зөрчжээ.

Уг нэгжийн үржлийн мал сүрэгт үзлэг ангилалт хийсэн байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна.

	Сумдын нэр	Малын үүлдэр, омог	Ангилалтад хамруулах малын төлөвлөгөө	Ангилалтад хамрагдсан малын тоо	Цөм сүрэгт тэнцсэн	Үржлийн сүрэгт тэнцсэн	Хэрэгцээний сүрэгт тэнцсэн
1	Дөрвөлжин	Буурал үүлдрийн ямаа	4250	4336	349	3081	906
2	Дөрвөлжин	Сартуул үүлдрийн хонь	2200	2168	211	1322	635
3	Яруу	Сартуул үүлдрийн хонь	3000	2955	343	2211	35
4	Яруу	Завхан буурал үүлдрийн ямаа	4200	4249	363	3650	236
5	Алдархаан	Сартуул үүлдрийн хонь	1000	1571	76	1297	198
6	Алдархаан	Завхан буурал үүлдрийн ямаа	1000	1195	101	891	203
7	Улиастай Малын удмын сангийн үндэсний төв	Завхан буурал үүлдрийн ямаа	250	129	129	0	0
8	Улиастай Малын удмын	Сартуул үүлдрийн хонь	2550	2298	2124	0	174

	сангийн үндэсний төв						
9	Баянтэс	Тэс омгийн адуу	200	130	31	88	11
10	Баянхайрхан	Тэс омгийн адуу	125	212	33	165	14
11	Тэс	Тэс омгийн адуу	175	167	90	66	11
Дүн			18950	19410	3850	12771	2423

2020 онд 8 сумын 12450 толгой үржлийн малд үзлэг ангилалт хийж, баталгаажуулахдаа 5 мал үржүүлэг, технологийн нэгжтэй гэрээ байгуулан 22,125.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Гэрээний биелэлтийг шалгахад мал үржүүлэг, технологийн нэгжүүд нь 22894 толгой малд үзлэг ангилалт хийн, 6545 толгой малыг цөм сүрэгт тэнцүүлсэн, адуунаас бусад малыг ээмэгжүүлсэн байна.

Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний жишиг үнэ, гэрээ, үзлэг ангилалтын журналтай танилцахад мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжүүд нь малд үзлэг ангилалт хийхдээ гадна шинж тэмдгээр нь ангийн ангилалтыг бүрэн хийдэг бөгөөд зөвхөн цөм сүргийн шаардлага хангасан малыг галбир бие цогцсын босго үзүүлэлтээр хэмждэг байна.



”Жаргалант мал сүрэг”, “Сартуул сүрэг”, “Окусан”, “Хатан шонхорын үрс” зэрэг мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжүүдийн гүйцэтгэсэн малын ангилалт үзлэгээр бүрдүүлсэн цөм сүргийн тоо хэмжээ нь шаардлагын хэмжээнд хүрээгүй байгааг илрүүллээ. Цаашид ХХААГ-аас малын үзлэг ангилалтыг хийлгэх гэрээндээ цөм сүрэг бүрдүүлэх шаардлагатай тоо хэмжээг тусгахаас гадна шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгч бойжуулах чиглэлийг тусган хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Үзлэг ангилалтад хамарсан малыг малын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд, цөм сүрэгт тэнцсэн малыг Малын удмын сангийн бүртгэлийн программд бүрэн бүртгэсэн байна.

Үржлийн малд үзлэг ангилалт хийх ажлын үр дүн 2020 онд өмнөх оноос сайжирсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ ТАЙЛАГНАЛД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1.Хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн тайлагнал шаардлагын түвшинд хүрээгүй байна.

2.1.1.Үлийн цагаан оготнотой тэмцэх төсөл хөтөлбөрийн тайлагнал нотлох баримтаар бүрэн нотлогдохгүй байна.

2019 онд үлийн цагаан оготнотой тэмцэх 56,000.0 мянган төгрөгийн зардлын тайлагнал шаардлага хангаж байгаа эсэхийг шалгахад Сонгино, Эрдэнэхайрхан сумдын Засаг дарга нарын 15,950.0 мянган төгрөгийн зардлын тайлагналд зөрчил илрээгүй.

Харин дараах сумдын тайлагналд 17,827.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.Үүнд:

<u>Аудитын илрүүлэлт:</u>
<i>Цэцэн-Уул сумын Засаг дарга үлийн цагаан оготнотой тэмцэх зардлын 8,700.0 мянган төгрөгийг хувь хүний дансаар дамжуулан зарцуулж, Төрийн сангийн төлбөр тооцооны журмыг зөрчсөн</i>
<i>Тэс сумын Засаг дарга нь 7,597.2 мянган төгрөгийн үлийн цагаан оготнотой тэмцэх зардлыг иргэдэд тэмцсэн ажлын хөлсөнд тооцож олгосон боловч тэмцсэн ажил нь нотлох баримтаар дэмжигдээгүй тул хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн</i>
<i>Тэс, Тосонцэнгэл сумдын Засаг дарга нар 1,530.0 мянган төгрөгийн үлийн цагаан оготнотой тэмцэх зардлыг зориулалт бусаар зарцуулсан тул төлбөрийн акт тогтоолоо</i>

2020 онд үлийн цагаан оготнотой тэмцэх 137,792.1 мянган төгрөгийн зардлын тайлагнал шаардлага хангаж байгаа эсэхийг шалгахад 10 сумын Засаг дарга нарын 80,348.5 мянган төгрөгийн зардлын тайлагналд зөрчил илрээгүй. Харин дараах сумдын Засаг дарга нарын ирүүлсэн тайлагнал нотлох баримтаар бүрэн дэмжигдээгүй байна.

<u>Аудитын илрүүлэлт:</u>
<i>Сантмаргац, Түдэвтэй, Ургамал сумдын Засаг дарга нар төсөвт байгууллагуудаас олгосон 1,991.7 мянган төгрөгийн шатахууны хандивыг үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын гүйцэтгэлд оруулалгүй орхигдуулсан.</i>

Идэр, Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн сумдын Засаг дарга нар 7,730.4 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын баримтыг аймгийн ХХААГ-т дутуу ирүүлсэн
Тэс, Яруу, Ургамал сумын үлийн цагаан оготнотой тэмцсэн ажлын тайлагналд газар нутгийн нэр байршил, талбайн хэмжээг тусгаагүй
Цагаанхайрхан, Алдархаан сумдын Засаг дарга нар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын хэсэгт санхүүгийн ажилтнуудыг оролцуулаагүй, 2,000.4 мянган төгрөгийн тэмцэх ажлын зардал нь нотлох баримтаар дэмжигдээгүй, гүйцэтгэсэн эсэх нь тодорхойгүй байна.

Малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх болон малын генетик нөөц, төлөв байдлыг үнэлэх ажлын тайлагналд зөрчил илрээгүй.

2.1.2. Төсөл хөтөлбөрийн үр дүнг хангалттай түвшинд тооцоогүй байна.

2019 онд үржлийн малд үзлэг ангилалт хийсэн “Жаргалант мал” мал үржүүлэг, технологийн нэгжийн ажлыг дүгнэхдээ аймгийн МХГ-ын малын үржлийн хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулахаар зөвлөмжийг өгч, гэрээний биелэлтийг 100 хувиар дүгнэсэн байна.

Мөн үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын үр дүнг Тосонцэнгэл, Цэцэн-Уул, Сонгино, Эрдэнэхайрхан сумын Засаг дарга нар тооцсон байна.

2020 оны үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын үр дүнг Цагаанхайрхан, Яруу, Эрдэнэхайрхан, Тэс, Идэр, Цэцэн-Уул, Тэлмэн, Сантмаргац сумын Засаг дарга нар тооцсон, бусад сумын Засаг дарга нар тооцоогүй байна. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын үр дүнг аймгийн хэмжээгээр нэгтгэн тооцоогүй байна.

Малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх ажлын үр дүнг тооцоогүй байна.

2.2. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт шаардлагын түвшинд хүрээгүй байна.

2.2.1. Төсөл хөтөлбөрийн үр дүнд аймгийн ХХААГ-аас тавих хяналт шаардлагын түвшинд хүрээгүй байна.

2019 онд аймгийн ХХААГ нь үлийн цагаан оготнотой тэмцэх зардлаас хяналтын зардалд 5,250.0 мянган төгрөгийг зарцуулан, хариуцсан мэргэжилтэн нь сумдад явцын хяналт тавьсан ч хяналтын тайлангаа ирүүлээгүй, дүн шинжилгээ хийгээгүй байна.

2020 онд сумдаас ирүүлсэн үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын тайлангаас харахад аймгийн ХХААГ нь үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын үр дүнг тооцох,

тайлагналын бодитой байдал, зарцуулалтын баримтын бүрдэл зэрэгт хяналт тавиагүй байна.

Малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх ажлын үр дүнд аймгийн ХХААГ-аас 2020 оны 5 дугаар сард Тэс, Баянтэс сумдыг хамруулан хяналт тавин 3 зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг аудитын хугацаанд ирүүлээгүй болно.

2.2.2. 2020 онд төсөл хөтөлбөрийн үр дүнд холбогдох хяналтын байгууллагууд хяналт тавиагүй байна.

2019-2020 оны үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын үр дүнд Тосонцэнгэл, Цэцэн-Уул, Сонгино, Эрдэнэхайрхан, Алдархаан, Тэлмэн зэрэг сумдын байгаль орчны улсын байцаагч нар хяналт тавин дүгнэлт гаргасан.

Малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх ажлын үр дүнд аймгийн МХГ 2019 оны 11 сард хяналтыг хийсэн байна. Аймгийн МХГ-ын мал үржлийн улсын байцаагчийн дүгнэлтээр Малын удмын сангийн үндэсний төвийн 2298 бог мал, Алдархаан, Яруу, Дөрвөлжин сумын 16476 бог мал, Тэс, Баянтэс, Баянхайрхан сумдын 509 адуунд хийсэн үзлэг ангилалтын ажлыг хянан үзэж, цөм сүргээр баталгаажсан малын хээлтэгч, хээлтүүлэгчийн хянан баталгаажилтын дүнг 97.2 хувьтай байна гэж дүгнэсэн байна.

2020 онд үлийн цагаан оготнотой тэмцэх ажилд холбогдох яам болон мэргэжлийн байгууллагаас хяналт хийгээгүй байна.

Аудитаар 1,530.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 21,780.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэн, 7,597.2 мянган төгрөгийн зөрчлийг шалгуулахаар хуулийн байгууллагад шилжүүлэн, 42,635.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

Дүгнэлт: ТАЙЛАНТ ОНД ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД ХАНГАЛТТАЙ ТҮВШИНД ХЭРЭГЖСЭН Ч ҮР ДҮНД НЬ АЙМГИЙН ХХААГ-ААС ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



**ЗАВХАН АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-2842
И-мэйл: uhaag_mn@yahoo.com

2021.06.24 № 105

танай _____-ны № _____ т

Санал хүргүүлэх тухай

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжин хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд аудит хийж дүгнэлт, зөвлөмж ирүүлсэнтэй урьдчилсан байдлаар танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

Тус аудитын дүгнэлтээс харахад төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэн, тодорхой үйл ажиллагаанууд дээр зөрчлүүд гарсан, эдгээр нь олон байгууллага, мэргэжилтнүүдийн үйл ажиллагаатай холбоотой, нарийвчлан дүгнэхэд баримт, мэдээлэл дутуу хүндрэл гарсан байна.

Гарсан зөрчлүүдийн мөрөөр ажил зохион байгуулах, үүрэг даалгавар өгөх, гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөх, хамтран ажиллах, ажлын үр дүнг эргэж тооцох замаар алдааг залруулах бүрэн боломжтой байгаа тул нөхцөл байдал, цаг хугацааны хувьд шинээр ажилд томилогдсон зэргийг харгалзан хариуцлага тооцуулах асуудлыг өөрчилж өгөхийг хүсье.

ДАРГА  **Н. БАТБАЯР**



618121065
D:\2021\AN OFFICIAL LETTER\4-2020.DOCX

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

2020 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүн өмнөх оноос сайжирсан тул удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн хариуцлага тооцуулах асуудлыг тайлангаас хаслаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймгийн ХХААГ нь 2019 онд Тосонцэнгэл, Тэс, Сонгино, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Цагаанхайрхан зэрэг сумдад 50,250.0 мянган төгрөгийн санхүүжилтийг үлийн цагаан оготнотой тэмцэхэд зориулан олгож, хяналтын зардалд 5,250.0 мянган төгрөгийг зарцуулсан
2. 2019 онд үлийн цагаан оготнотой тэмцэх шаардлагатай гэж дүгнэсэн талбайн 10.2 хувийг хамруулахаас 6.2 хувийг хамруулснаас харахад үлийн цагаан оготно устгах ажлын үр дүн шаардлагын түвшинд хүрээгүй байна .
3. 2020 онд үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын 157.5 сая төгрөгийн санхүүжилтийг 21 сумдад ирүүлсэн саналыг үндэслэн хуваарилсан
4. 2020 онд үлийн цагаан оготнотой тэмцэх шаардлагатай гэж дүгнэсэн талбайн 7 хувийг хамруулахаас 13.5 хувийг хамруулсан тул үлийн цагаан оготно устгах ажил үр дүнд хүрсэн байна.
5. Сумдын Засаг дарга нар харилцан адилгүй зардлаар үлийн цагаан оготнотой тэмцсэн нь аймгийн ХХААГ-аас төлөвлөлт, гүйцэтгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байсантай холбоотой байна.
6. Орон нутгийн төсвөөс хуваарилагдсан үлийн цагаан оготнотой тэмцэх зардлын 67.7 хувийг сумдын Засаг дарга нар үр дүнтэй зарцуулсан
7. Малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх ажлын гүйцэтгэгчид гэрээний үүргээ бүрэн хэрэгжүүлсэн
8. 2020 онд сумдын Засаг дарга нар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг тайлагнахдаа ХХААГ-аас хуваарилсан болон төсвийн байгууллагуудаас олгосон шатахууны дэмжлэгийг нэгтгэж тайлагнаагүй байна.
9. Төсөл хөтөлбөрийн үр дүнг хангалттай түвшинд тооцоогүй байна.
10. 2020 онд төсөл хөтөлбөрийн үр дүнд холбогдох хяналтын байгууллагууд хяналт тавиагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлсэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн ХХААГ-ын дарга Н.Батбаярт

1. Үржлийн мал сүрэгт үзлэг ангилалт хийх гүйцэтгэгчийг сонгохдоо мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжүүдийн өмнөх онд гүйцэтгэсэн ажлын үр дүнг харгалзан үзэх, малын үзлэг ангилалтыг хийлгэх гэрээндээ цөм сүрэг бүрдүүлэх шаардлагатай тоо хэмжээ болон шаардлага хангасан хээлтүүлэгчийг үржүүлэх чиглэлийг тусгах
2. ХХААГ-аас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн төлөвлөлт, явц, үр дүнд тавих дотоод хяналтыг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, хөтөлбөрүүдийн үр дүнг тооцож хэвших,
3. ХХААГ-аас малын үзлэг ангилалтыг гүйцэтгэж байгаа мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн гэрээг дүгнэж хэвших, нэгжид олгосон санхүүжилт зориулалтын дагуу бүрэн зарцуулагдсан эсэхийг хянах, дутуу гүйцэтгэлийг залруулах арга хэмжээ авах
4. Сумдад үлийн цагаан оготнотой тэмцэх зардлыг хуваарилахдаа оготны тархалтын судалгаанд үндэслэх, сумдад үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулах талбайг аль болох хил залгаа байхаар төлөвлөх, тэмцэх талбайн хэмжээнд хяналт тавих, тэмцсэн ажлын үр дүнг тооцох

Сумдын Засаг дарга нарт:

1. Үлийн цагаан оготнотой тэмцэх зардлыг зарцуулахдаа Төрийн сангийн төлбөр тооцооны журмыг мөрдөн, хувь хүний дансаар дамжуулан зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох
2. Үлийн цагаан оготнотой тэмцэх зардлыг багуудад хуваарилахдаа оготны тархалтын судалгаанд үндэслэх, багуудад үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулах талбайг аль болох хил залгаа байхаар төлөвлөх, 1 га талбайн зардлыг тогтоосон хэмжээнд мөрдөх

3. Үлийн цагаан оготной тэмцэх ажлын явцад тавих хяналтыг сайжруулах, тэмцсэн ажлын гүйцэтгэлийг нотлох баримтаар баталгаажуулан, аймгийн ХХААГ -т хугацаанд нь хүргүүлэх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА